



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 24 өдөр

Дугаар А/09

Эрдэнэт

**Ээлжит хуралдааны хугацааг
өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавирус халдварт цар тахлын нөхцөл байдал болон цаг үеийн ажлын шаардлагыг харгалзан 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зарласан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит VII хуралдааныг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 09.00 цагт Эрдэнэт хотод цахимаар хуралдуулахаар хугацааг өөрчилсүгэй.

2. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний төслийг хавсралтаар баталсугай.

3. Хуралдааны бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Д.Эрдэнэцэцэг)-т даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны 01 дүгээр сарын 4-ны өдрийн 1/0 дугаар захирамжийн хавсралт

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ ҮИИ ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ
АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛ**

1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн шалгуур үзүүлэлтийн 2021 оны тайлангийн тухай

Илтгэгч нь: Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга С.Даваадорж

2. “Ногоон Эрдэнэт” хөтөлбөр батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

3. Орхон аймгийн “Аялал жуулчлалын хөтөлбөр” батлах тухай

Илтгэгч нь: БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан

4. “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр” батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал

5. 2022 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээ батлах тухай

Илтгэгч нь: БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан

6. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын 2021 оны төлөвлөгөөний биелэлтийн тайлан, 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: ОБГ-ын дарга Г.Ганбаатар

7. Иргэний зөвлөлийн 2021 оны тайлангийн хэрэгжилт, 2022 оны төлөвлөгөө батлах тухай

Илтгэгч нь: Иргэний зөвлөлийн дарга Х.Бат-Эрдэнэ

8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны “Үлгэрчилсэн дэг” батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэг

9. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хорооны үйл ажиллагааны журам” батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын даргын зөвлөх Ш.Ганбат

10. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм” батлах тухай

Илтгэгч нь: Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын даргын зөвлөх Ш.Ганбат

11. “Төлөөлөгчийн энгэрийн тэмдэг, үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудасны загвар, хэрэглэх журам” батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Эрдэнэцэцэг

12. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөл байгуулах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

13. Хороод шинэчлэн батлах тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

14. Нутгийн удирдлагын төлөөллийн байгууллагын Төлөөлөгчийг сонгох тухай

Илтгэгч нь: Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат

15. Бусад